



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.09.17 № 38

Монгол Улсын 2026 оны төсвийн
төслийн талаар

Монгол Улсын тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтад зааснаар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3 дахь заалтад зааснаар Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байхаар тус тус хуульчилсан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад заасныг тус тус үндэслэн дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан нийт хэдэн төгрөгийн үнийн дүн бүхий хэдэн төсөл, арга хэмжээг тусгасан талаарх мэдээллийг төсөл, арга хэмжээ тус бүрээр гарган ирүүлэх;

2. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд батлагдаагүй нийт хэдэн төгрөгийн үнийн дүнтэй, хэдэн төсөл, арга хэмжээг тусгасан талаарх мэдээллийг төсөл, арга хэмжээ тус бүрээр.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

М.БАДАМСҮРЭН



2025000064